



Брокер Дилер Андеррайтерийн Компани

2018 он 08 сарын 02 өдөр
Дугаар № 08/24

Монголын Хөрөнгийн
Бирж-д

Хуваарилалтын төлөвлөгөө хүргүүлэх тухай:

"Бумбат Алтай ҮЦК" ХХК нь "Хөвсгөл Алтандуулга" ХК-н олон нийтэд нэмж үнэт цаасаа санал болгох ажлын андеррайтераар ажиллаж байна. Уг ажлыг амжилттай зохион байгуулах хүрээнд хавсралтаар "Үнэт цаасны анхдагч зах зээлийн хуваарилалтын төлөвлөгөө"-г хүргүүлж байгааг хүлээн авч, хянаж өгнө үү.

Хавсралт: 1) Анхдагч зах зээлийн хуваарилалтын төлөвлөгөө /1 хуудас/

ХҮНДЭТГЭСЭН,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ш.ЭНХМЭНД

Утас: 99968989,70112166
Цахим хаяг: bumbatai_21@yahoo.com
Хаяг: 41 тоот, 4-р хороо 16/4 байр
Чингэлтэй дүүрэг Улаанбаатар хот
Монгол Улс



ҮНЭТ ЦААСНЫ ХУВААРИЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

"Хөвсгөл Алтандуулга" ХК нь олон нийтэд 4,405,600 ширхэг хувьцааг санал болгож 3.74 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэхээр зорьж байна.

Энэ хүрээнд хувьцааны захиалга нь 2 үндсэн хэсэгт хуваагдах бөгөөд олон нийтийн болон стратегийн хөрөнгө оруулагчдад тус тус санал болгоно.

1/ 1.0 тэрбум төгрөгийн (1,177,000 ширхэг) хувьцаа нь нээлттэй арилжаанд оролцох эрхтэй хувьцаа байх буюу FPO амжилттай болсон даруйд хоёрдогч зах зээлийн эргэлтэнд орох боломжтой байна. МХБ-н "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-н 3.3-т заагдсан буюу захиалгын бүртгэлийн аргаар санал болгогдоно. Нэгж хувьцааны санал болгож буй доод үнэ нь 850 төгрөг байна.

мөнгөн дүн /доод/	Биелэлт
1.0 тэрбум төгрөг	Хөрөнгө оруулагчид 850 төгрөг буюу түүнээс дээш үнээр худалдан авах захиалга өгөх боломжтой. Нийт ирсэн захиалгын саналд үндэслэн санал болгож буй 1,177,000 ширхэг хувьцаа бүрэн биелэгдэх боломжтой үнийг Андеррайтер болон Үнэт цаас гаргагч хамтран тогтооно. Үнийг тогтоосны дараа тогтоосон үнэ болон түүнээс дээгүүр үнээр захиалга өгсөн этгээдэд цаг хугацааны болон үнийн ахлах дарааллаас үл хамаарч захиалсан хувьцааны тоонд хувь тэнцүүлэн хуваарилна.

2/ 2.74 тэрбум төгрөгийн (3,228,600 ширхэг) нь хаалттай буюу 6 сарын хугацаанд арилжаанд оролцох эрхгүй байх нөхцөлийг зөвшөөрсөн стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгох хувьцаа байх буюу FPO амжилттай болсонд тооцогдсоны дараах 6 сарын хугацаанд хоёрдогч зах зээлийн эргэлтэнд орох боломжгүй байна.

Энэхүү нөхцөлийг зөвшөөрсөн Анхдагч зах зээлийн худалдан авах захиалгыг андеррайтер "Бумбат Алтай ҮЦК" ХХК хүлээн авч шийдвэрлэнэ.

мөнгөн дүн	Биелэлт
2.74 тэрбум төгрөг	Стратегийн хөрөнгө оруулагчдад нэгж хувьцааг тогтсон 850 төгрөгөөр санал болгоно. Андеррайтерийн компани захиалга хүлээн авч хуваарилна.